

АЙМГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ
(Аймгийн Засаг даргын Тамгын газар)

Бүтэц	№	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Санхүүжлтийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилт от түвшин /2021 он/	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (Хүрээгүй бол шалтгаан нөхцөл тайлбар)
					Он	Түвшин		
Ерөнхий чиг үүргийн нэр: 1. Байгалийн баялаг, байгаль орчин, аялал жуулчлал								
Үндсэн чиг үүргийн нэр: 1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, орчны бохирдлыг бууруулах								
Зорилт	1.	Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг 4 хувиар бууруулна.		Агаар, хөрсний бохирдлын бууралт	2020	1	1.5	Төв суурин газрын орчны бохирдлын бууралтын хувийг бохирдуулагч эх үүсвэрийн бууралтын хувиар дундажлан тооцдог ба эхний хагас жилийн байдлаар уул уурхайн бүсэд 10 ширхэг, гэр хороололд 8 сайжруулсан ариун цэврийн байгууламж нэмэгдэж нийт гэр хороолол болон уул уурхайн бүсийн хөрсний бохирдлын хэмжээ 0.2 хувиар багассан үзүүлэлттэй буюу бууралтын хувь 1.2-т хүрэв. Гүйцэтгэлийн хувь 40
Арга хэмжээ	1	Агаарт агуулагдаж байгаа тоос тоосонцорыг хэмжих зөөврийн багажтай болж, 3 төрлийн бодисыг бүрэн хэмждэг болж, агаарын чанарын индексээр үнэлнэ.		Агаарын чанарын индексийн түвшин	2020	0	-	2021 онд зорилтот түвшин төлөвлөөгүй
	2	Утаа бага ялгаруулдаг төвлөрсөн халаалтын зуухны тоог нэмэгдүүлэх		Утаа бага ялгаруулдаг зуухны тоо	2020	2	-	2021 онд зорилтот түвшин төлөвлөөгүй
	3	Гэр хороолол болон үйлдвэрлэл, үйлчилгээ		Гэр хорооллын сайжруулсан	2020	28	30	Аймгийн хэмжээнд “Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх, албан

		(аялал жуулчлал, уул уурхай, шатахуун түгээх станц г.м)-ний бүсэд сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонгын тоог нэмэгдүүлэх		ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь				байгууллага шалгаруулах” болзолт уралдааныг 4 сарын хугацаатай зарлаад байна. 2021.11.09-нд уралдааныг дүгнэнэ. Гүйцэтгэлийн хувь 0
				Үйлдвэрлэл, үйлчилгээний бүс дэхь сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонгийн эзлэх хувь	2020	20.5	25	Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг “Үнэн Анд” ХХК өөрийн 9.2 сая төгрөгийн хөрөнгөөр 10 ширхэг сайжруулсан ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулж, ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламжийг бий болгож ашиглалтад оруулсан. БОАЖГазраас улсын тусгай хамгаалалттай “Дэлгэрхангай уул”-нд байгаль орчинд ээлтэй 2 эко ариун цэврийн байгууламжыг суурилуулж, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Хустайн Байгалийн Цогцолборт газар болон “Шийдэл - Аялал Жуулчлалын Бүтээмжийн Төв” ТББ хамтран хэрэгжүүлж буй хуурай “Ногоон 00” төсөлд тус аймгийн Цагаан суварга болон Бага газрын чулуу байгалийн үзэсгэлэнт газарт гэр буудлын үйл ажиллагаа эрхэлдэг 3 малчин өрх хамрагдснаар үйлдвэр үйлчилгээний бүсэд эзлэх сайжруулсан ариун цэврийн байгууламж 15-аар нэмэгдэж 26.4 хувийг эзэлж байна. Гүйцэтгэлийн хувь 100
Зорилт	2	Хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрт 2024 он гэхэд 46 тонн дахивар хогийг нийлүүлнэ.		Дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ	2020	5	10	Хулд суманд 2 нэр төрлийн, Сайнцагаан суманд 5 нэр төрлийн дахивар хог авах цэг байгуулагдаад байгаа бөгөөд одоогоор Сайнцагаан сумын цэг хог хаягдал хүлээн авах бэлтгэл ажлыг хангаж, Хулд суманд 0.1 тн дахиварыг цуглуулсан ба Хулд сумын Засаг даргын санаачилгаар төвийн 18 өрхийн ашиглах боломжгүй болсон 45 тээврийн хэрэгслийн 10 тн төмрийн хаягдлыг орон нутгийн төсвийн 0.6 сая төгрөгийн хөрөнгөөр Улаанбаатар хот руу 2 удаа

								тээвэрлэлт хийснээр дахин боловсруулах үйлдвэрт тушааж орлогыг иргэдэд олголоо. Гүйцэтгэлийн хувь 100
Арга хэмжээ	1	Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, булшлах		Шууж булшилсан талбайн хэмжээ	2020	7.4	10	Дэлгэрцогт сумын 30.4 га талбайг хамарсан хогийн цэгийг шууж шинэчлэх ажлыг ОНТөсвийн 66.6 сая төгрөгийн хөрөнгөөр “АКШУС” ХХК-аар гүйцэтгүүлэв. Дэрэн сумын төвлөрсөн хогийн цэгийн гадуур тархсан 3 га талбайн хог хаягдлыг шуух ажил ОНТөсвийн 3 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 хувьтай үргэлжилж байна. Гүйцэтгэлийн хувь 100
	2	Ангилан ялгах хогийн савны тоог нэмэгдүүлэх		Нэмэгдүүлсэн хогийн савны тоо	2020	25	30	Хог хаягдлын менежментийг сайжруулах, ангилан ялгах тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд БОАЖГазраас санал тавьсны дагуу 2 ААНэгжтэй хамтран хувийн хэвшлийн 1.6 сая төгрөг, ОНТөсвийн 0.75 сая төгрөгөөр Сайнцагаан сумын 3 Ерөнхий боловсролын сургуульд хуванцар хог хаягдал цуглуулах, нийтийн эзэмшлийн талбайн 2 байршилд ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг байршуулав. Сайхан-Овоо сумын төвийн айл өрхүүдэд ОНТөсвийн 31.9 сая төгрөгөөр 115 ширхэг ангилан ялгах зориулалт бүхий савыг байршууллаа. Аймгийн хэмжээнд нийт 120 ангилан ялгах хогийн сав байршууллаа. Гүйцэтгэлийн хувь 100
Үндсэн чиг үүргийн нэр:2. Усны нөөцийг бохирдол, хомсдлоос хамгаалах								
Зорилт	1	Усны бохирдол, хомсдлоос сэргийлж, шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь 2020 онд 26.5 байсныг 2024 онд 30 хувьд хүргэнэ.		Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	2020	26.5	27	Эхний хагас жилийн байдлаар хүн амын 26.75 хувь нь шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан. Гүйцэтгэлийн хувь 50
Арга хэмжээ	1	Төв суурин газрын ундны усны чанар стандартыг		Тухайн жилд суурилуулсан	2020	-	2	Баянжаргалан сумын төвийн ундны усны эх үүсвэр дээр орон нутгийн хөгжлийн сангийн

		сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 8 эх үүсвэрт суурилуулах.		төхөөрөмжийн тоо				49 сая төгрөгийн хөрөнгөөр 2 тн нөөцийн савтай цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулав. Гүйцэтгэлийн хувь 50
	2	Усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах.		Хамгаалалтын бүс тогтоосон булгийн тоо	2020	-	20	Усны сан бүхий газрын байршлын суурин боловсруулалт буюу хээрийн хэмжилт, уст цэгийн тоо бүртгэлийн дүн, МС1:100'000 байр зүйн зураг, хиймэл дагуулын мэдээллийг нэгтгэн усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийг зурагжуулах ажлыг гүйцэтгэв. Тэмдэгжүүлэх ажил 3 сумын 23 булгийн эх дээр хийгдэж байна. Гүйцэтгэлийн хувь 30
	3	Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах.		Хашсан булгийн тоо	2020	53	56	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Гурвансайхан сумын “Баян булаг”, Өлзийт сумын “Рашаант булаг”, Дэлгэрцогт сумын “Адгийн булаг”-ийн эхийг хашиж хамгаалахаар сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулж урьдчилгаа санхүүжилтийг шилжүүлсэн. Үүнээс Гурвансайхан сумын “Баян булаг”-ийн эхийг хашиж хамгаалах ажил 100% -ийн гүйцэтгэлтэйгээр хийгдэж дууссан. Гүйцэтгэлийн хувь 33
Үндсэн чиг үүргийн нэр:3 Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх								
Зорилт	1	Ногоон байгууламжийн хэмжээ 2020 онд 369.4 га байсныг 2024 онд 419.4 га-д хүргэж, ургалтын хувийг нэмэгдүүлнэ.		Ногоон байгууламжийн хэмжээ		369.4	399.4	“Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд улсын чанартай авто зам дагуу 25 га-д 15000 мод, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд 5 га нийт 30 га газарт ойн зурвас байгуулав. Гүйцэтгэлийн хувь 50
				Ургалтын хувь		75	77	/Амьдралтын хувийг тодорхойлох хугацаа болоогүй/

Арга хэмжээ	1	Тухайн жилийн сумдын ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламж хийх газрын байршил, талбайн хэмжээг тусган батлуулах		Батлагдсан эсэх		1	1	Сайнцагаан сумын ИТХ-ын 2020 оны 12 тоот тогтоолоор “Арвижих төгөл”-д 5 га талбайг 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан баталсан. Гүйцэтгэлийн хувь 100
	2	Төв зам дагуу болон цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, өргөтгөх.		Ногоон байгууламжийн хэмжээ		5	5	Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Дэрэн, Гурвансайхан, Говь-Угтаал сумдад тус бүр 1 га нийт 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлын гэрээ байгуулж 3000 мод сөөг, засмал зам дагуу Сайнцагаан сум 15553, Луус сум 364 мод нийт 15917 мод тус тус тарьж усалгаа арчилгаа хийж байна. Гүйцэтгэлийн хувь 100
	3	Хөрс хамгаалах, газрын доройтлын бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх.		Ногоон байгууламжийн хэмжээ		-	25	“Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх” хөтөлбөрийн хүрээнд Мандалговь-Улаанбаатар чиглэлийн улсын чанартай авто зам дагуу Цагдаагийн хяналтын постноос- Дундговь худалдааны төв хүртэл Агч, Улиас, Хайлаас 3 төрлийн 15553 ширхэг мод тарьж усалгаа арчилгааг хийж байна. Гүйцэтгэлийн хувь 100
	4	Иргэн, ААНБайгууллагыг өөрийн болон нийтийн эзэмшлийн талбайд мод сөөг тарих ажлыг зохион байгуулах		Жилд тарьсан модны тоо		13845	14000	“Мод тарих үндэсний өдөр”-өөр аймгийн хэмжээнд 468 өрх, 127 аж ахуйн нэгж, байгууллагын 2589 иргэн 44295 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж байна. Гүйцэтгэлийн хувь 100
Үндсэн чиг үүргийн нэр:4 Газрын доройтлыг бууруулах, байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх								
Зорилт	1	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбай 2020 онд 80.6 га байсныг 2024 онд 100 га-р нэмэгдүүлнэ.		Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ		80.6	105.6	Нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, эвдэрсэн газрыг бууруулах зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг зохион байгуулах аймгийн Засаг даргын 2021 оны 1/26 захирамжаар ажлын хэсгийг байгуулан 20 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. 8 сумын нутаг дэвсгэрт 11.8 га талбайд нөхөн сэргээлт хийгдэж нийт

								нөхөн сэргээлт 91.4 га талбайд хийгдсэн байна. Гүйцэтгэлийн хувь 43.2
Арга хэмжээ	1	Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 80 га-р нэмэгдүүлэх		Техникийн нөхөн сэргээсэн талбайн хэмжээ		79.6	99.6	Сайнцагаан, Гурвансайхан, Өлзийт, Дэлгэрхангай, Өндөршил, Баянжаргалан, сумдын нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн 7.6 га, дэд бүтцийн улмаас эвдэрсэн 2.2 га талбайд тус тус нөхөн сэргээлт хийж, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай 89.4 га-д хүрсэн байна. Гүйцэтгэлийн хувь 49
	2	Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 20 га-р нэмэгдүүлэх		Биологийн нөхөн сэргээсэн талбайн хэмжээ		1	6	Эрдэнэдалай суманд 2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн. Гүйцэтгэлийн хувь 40
	3	Уул уурхайн төслийн байгаль орчныг хамгаалах, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх		үр өгөөжийг нэмэгдүүлсэн төслийн тоо		5	10	Баянжаргалан Аргийн хад ОНТХГ-т уст цэг байгуулах, ИГЧБЦГазарт 50 тарвага нутагшуулах ажлыг “Монголын алт” ХХК, “Мак цемент ХХК”-аас тус тус санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Гурвансайхан суманд “Эрдэнэс силвер ресурс” ХХК-аас ИГЧБЦГазарт ногоон байгууламж бий болгох зэрэг төслүүд орон нутагт хэрэгжиж байна. Гүйцэтгэлийн хувь 60
	4	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулах		Нэгдсэн хяналт шалгалтын тоо		1	2	Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас – Дундговь аймгийн нутгаар дамжин Говь-Сүмбэр аймгийн чиглэлийн нүүрс тээврийн хүнд даацын автомашинууд улсын тусгай хамгаалалттай 2 газраар дайран өнгөрч байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 03-ны А/174 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан тусгай хамгаалалттай газруудыг тойрон өнгөрүүлэх шинэ маршрут гаргах ажлаар 4 удаа хяналтаар явж,

								зөрчилтэй тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг тухай бүрд тавьж ажиллалаа. Сайнцагаан сумын “Хөрхийн хад” газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хууль бусаар олборлож буй зөрчилд мэргэжлийн байгууллагуудын хамт 1 удаагийн хяналт шалгалт хийж цаашид олборлолт хийхгүй байх талаар самбар байршуулан, энэ онд дүйцүүлэн хамгааллын хүрээнд тус 2 га газрыг нөхөн сэргээлгэхээр 1 аж ахуйн нэгжид үүрэг болгосон. Гүйцэтгэлийн хувь 50
Үндсэн чиг үүргийн нэр: 5 Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх								
Зорилт	1	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 27 хувь байсныг 2024 онд 33.8 хувьд хүргэнэ.		Нийт газар нутагт эзлэх хувь		27	27.5	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг сайжруулж “Дэлгэрхангай уул” улсын тусгай хамгаалалттай газарт тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн өнгө төрх брэндбүүкэд нийцүүлэн 12 цэгт хилийн багана, эрэгтэй эмэгтэй био 00, мэдээллийн самбар, орц гарцын хаалгыг хийж гүйцэтгэв. Мөн “Их адаацаг уул” сумын тусгай хамгаалалттай газрыг ангилал дээшлүүлж аймгийн ИТХурлын 5 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж батлав. Ингэснээр тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 0.5 хувиар нэмэгдэв. Гүйцэтгэлийн хувь 100
Арга хэмжээ	1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх		Улсын тусгай хамгаалалттай нутгийн хувь		5.7	5.7	2021 онд зорилтот түвшин төлөвлөөгүй
	2	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх		Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хувь		21.3	21.8	Адаацаг сумын Засаг даргын 1/145 албан бичгээр “Их адаацаг уул” сумын нутгийн тусгай хамгаалалттай газрыг ангилал дээшлүүлж аймгийн тусгай хамгаалалттай газар болгох санал ирүүлсэн. Тус бичгийг ХОХБТХэлтэст хүргүүлж аймгийн ИТХурлын 5 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж батлав.

								Ингэснээр тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 0.5 хувиар нэмэгдэв. Гүйцэтгэлийн хувь 100
Үндсэн чиг үүргийн нэр: 6 Биологийн олон янз байдлыг зохистой ашиглах, хамгаалах								
Зорилт	1	Зэрлэг амьтдын нөөцийг хамгаалан, зэрлэг амьтдын төл 2020 онд 35 байсныг 2024 онл 105 болгон нэмэгдүүлнэ.		Нэмэгдсэн зэрлэг амьтны төл		35	45	Биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг амьтдад зориулж хөдөлгөөн мэдрэгчтэй камер байрлуулах, биотехникийн арга хэмжээ, уст цэг, ховор ургамал хамгаалах, хяналт шалгалт, дүйцүүлэн хамгаалах зэрэг 14 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Гүйцэтгэлийн хувь 100
Арга хэмжээ	1	Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцлийг сайжруулж, идэш тэжээлийн хомсдолоос үүссэн зүй бус хорогдлоос сэргийлж, биотехникийн арга хэмжээ авах		Био техникийн арга хэмжээ		10	16	7 сумын 6 агнуурын бүс, 2 тусгай хамгаалалттай газарт биотехникийн арга хэмжээг 13 удаа 6.1 сая төгрөгөөр 600 боодол өвс, 20 тонн хужир, мараа тавьж ажиллалаа. Гурвансайхан, Өлзийт сумдад гандуу, хуурайшилттай жил болсон учир агнуурын бүсэд зэрлэг амьтдын хорогдлоос сэргийлж шинээр 2 уст цэг бий болгосон. Нийт 15 удаагийн биотехникийн арга хэмжээ авлаа. Гүйцэтгэлийн хувь 83.3
	2	Тарвага нутагшуулах ажлыг зохион байгуулах		Тухайн жилд нутагшуулсан тарваганы тоо		30	-	Дундговь аймгийн Улаанбаатар хот дахь залуучуудын холбооноос санаачлан “Хустайн нуруу” БЦГХЗахиргаатай хамтарч ажиллах гэрээ байгуулж 50 толгой тарвагыг Эрдэнэдалай суманд нутагшуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Гүйцэтгэлийн хувь 100
	3	Аймгийн хэмжээнд амьтан, ургамлын нарийвчилсан тооллогыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, нөөцийг тогтоох		Шинээр хийгдсэн судалгааны тоо		2	-	2021 онд зорилтот түвшин төлөвлөөгүй

	4	Биологийн төрөл зүйлийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, шаардлагатай судалгаа хийх		Тухайн жилд хийгдсэн судалгааны тоо		-	1	БОАЖЯам, Монголын анчдын нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан Монгол улсын аргаль, янгир, тахь, хар сүүлтийн судалгааг хийж гүйцэтгэв. Тус судалгааны хүрээнд Дундговь аймгийн 9 тусгай хамгаалалттай газарт аргаль, янгир, хар сүүлтийн тандалт, ажиглалтын судалгааг хийж гүйцэтгэв. Гүйцэтгэлийн хувь 100
Үндсэн чиг үүргийн нэр: 7 Аялал жуулчлалыг хөгжүүлэх								
Зорилт	1	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн гадаад, дотоод жуулчдын тоог 40000-д хүргэнэ.		Дундговь аймагт ирсэн гадаад, дотоод жуулчдын тооны өсөлт		19.5	15.0	Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулж гадаад, дотоодын жуулчдын ирэх нөхцөл боломжийг бүрдүүлэн сэргээн засварлах, тохижилтын ажил, хүний нөөц бүрдүүлэх, чадавхжуулах сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлуудыг зохион байгууллаа. Ковид-19 нөхцөл байдлаас шалтгаалан аймгийн үзэсгэлэнт газрууд болох Цагаан суварга, Бага газрын чулуу, Онгийн хийд, Их газрын чулуу, Сүм хөх бүрдээр 12000 гаруй дотоодын аялагчид аялсан. Гүйцэтгэлийн хувь 80
Арга хэмжээ	1	Аялал жуулчлалын нэгдсэн бодлого, мастер төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх		Батлуулсан эсэх		0	-	2021 онд төлөвлөгдөөгүй
				Тухайн жилийн хэрэгжилтийн хувь				2021 онд төлөвлөгдөөгүй
	2	Аялал жуулчлалын гол бүс нутгийг түшиглэсэн аялал жуулчлалын төв, цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулахыг бодлогоор дэмжиж, хүчин чадлыг нэмэгдүүлэх		Жуулчин хүлээн авах хүчин чадал		1004	1054	ДУГАОНӨГ/202106064 гэрээний дугаар бүхий “Сүм хөх бүрдэд аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр” /Адаацаг сум/ тендерийг зарласан. Тус тендерт “Аргил трейд” ХХК шалгарч тус баазад 3 цомцог гэр нийлүүлж, жуулчин авах хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Мөн аймгийн төвд сүлжээ зочид буудлыг барих ажлын суурь тавигдсан. Гүйцэтгэлийн хувь 100
	3	Аялал жуулчлалын газруудын үйлчилгээний		Үнэлгээний дундаж хувь		80	83	Тус аймгийн Стандарт хэмжээ зүйн хэлтсийн Чанарын баталгаажуулалтын алба нь 2021

	стандартын хэрэгжилтийн дундаж үнэлгээг дээшлүүлэх						оны 8 сарын 25-ны байдлаар тохирлын гэрчилгээ хүссэн Бага газрын чулуу байгалийн үзэсгэлэнт газарт үйл ажиллагаа явуулдаг “Говийн хүрхрээ” жуулчны баазад стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээг 2 жилийн хугацаатай олгосон. Гүйцэтгэлийн хувь 100
4	Жуулчдын голлон зорих газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулах		Байгуулагдсан отоглох цэгийн тоо		1	1	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/167 дугаар тушаалаар “Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах ажил”-ын гүйцэтгэгчээр “Акшус” ХХК-тай гэрээ байгуулсан. Тус ажлын явцад хяналт хийхэд гүйцэтгэл 70%-тай явж байгаа бөгөөд 2021 оны 09 дүгээр сарын 05-нд хүлээлгэж өгнө. Гүйцэтгэлийн хувь
5	Олон улсын үзэсгэлэнд оролцож, орон нутгаа сурталчилах		Жуулчин хүлээн авахаар байгуулсан гэрээний тоо		100	100	хугацаа болоогүй
6	Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг өргөжүүлэх		Цахим үйлчилгээнд хамрагдсан ААНэгжийн тоо		-	3	Дотоодын аялагчдад зориулсан нэгдсэн платформ www.joinme.mn хамтран ажиллах 21/01 тоот гэрээ байгуулсан. Үүний хүрээнд Дундговь аймгийн нэрийн хуудсыг үүсгэж мэдээ, мэдээллийг байршуулсан. Тус сайтад аймгийн аялал жуулчлалын 1 ресорт онлайн захиалгын системд холбогдон ажиллаж байна. Мөн БОАЖЯамны дэмжлэгтэй www.ihotel.mn -тэй хамтран аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын танилцуулга, мэдээллийн цахим үзэсгэлэнд тус аймгийн 4 жуулчны бааз урьдчилан захиалга авч оролцсон. Нийт цахим үйлчилгээнд 5 ААНэгж хамрагдсан. Гүйцэтгэлийн хувь 100

	7	Байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн морь, тэмээн аяллын хүрээ байгуулж, язгуур урлаг, өв соёлын эвент арга хэмжээ зохион байгуулах		Тухайн жилд зохион байгуулсан арга хэмжээний тоо		1	2	Адаацаг сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэ-Ухаа” жуулчны баазтай хамтран морин аялал явуулах төлөвлөгөө боловсруулж байна. /Хугацаа болоогүй/
	8	Нутгийн иргэдэд түшиглэсэн жуулчин хүлээн авах малчин өрхийн нэгдсэн сүлжээг бий болгож дэмжлэг үзүүлэх		Хамрагдсан малчин өрхийн тоо		-	10	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Говийн зэрэглээ” хэмээх төслийг Хулд сумын төвд эхлүүлж байна. Энэхүү төсөлд орон нутгийн 10 гаруй малчид хамрагдаж, ингэний сүү, хоормог нийлүүлж хамтарч ажиллана. Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Хустайн Байгалийн Цогцолборт газар болон “Шийдэл - Аялал Жуулчлалын Бүтээмжийн Төв” ТББ хамтран хэрэгжүүлж буй хуурай “Ногоон 00” төсөлд тус аймгийн Цагаан суварга болон Бага газрын чулуу байгалийн үзэсгэлэнт газарт гэр буудлын үйл ажиллагаа эрхэлдэг 3 малчин өрх хамрагдсан. Гүйцэтгэлийн хувь 30
Ерөнхий чиг үүргийн нэр: 2. Газрын харилцаа, барилга, хот байгуулалт								
Үндсэн чиг үүргийн нэр: 1. Барилга, хот байгуулалтын бодлого хэрэгжүүлэх								
Зорилт	1	2020 онд хот, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй 6 сум буюу 40 хувь байгааг 2024 онд 15 сумыг буюу 100 хувьд хүргэнэ.		Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон сумын тоо		6	9	2021 онд Хулд, Луус сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг “Сонголт дизайн” ХХК гүйцэтгэхээр 176,8 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд ажлын явц 40 хувьтай байна. Мөн Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг батлуулан хүргүүлсэн бөгөөд тендерийн шатанд байна. Гүйцэтгэлийн хувь 30
Арга хэмжээ	1	Аймгийн төвийн "Түмний хороолол", "Хаус хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий		Тухайн жилд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө",		0	2	Аймгийн төвийн "Түмний хороолол", "Хаус хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлыг эхлүүлсэн. Ажлын явц 20 хувь.

		төлөвлөгөө, ажлын зургийг батлуулах		ажлын зургийг батлуулах ажлын тоо				Гүйцэтгэлийн хувь 30
	2	Аймгийн төвийн 6.4 км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтын ажлын үргэжлүүлэх		Ажлын гүйцэтгэл		15	0	Аймгийн төвийн 6.4км үерийн хамгаалалтын далангийн барилга, байгууламжийн угсралтыг үргэжлүүлэх ажлыг Сангийн яамны rimis программд оруулан 2022 оны улсын төсөвт хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яамруу албан бичиг хүргүүлсэн. Гүйцэтгэлийн хувь 0
	3	Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгах, дахин төлөвлөх.		Буулгасан барилга байгууламжийн тоо		1	2	Сайнцагаан сумын Говийн ирээдүй цогцолбор сургуулийн барилгыг буулгаж, шинээр 960 суудалтай сургууль барихаар 2021 оны улсын төсөвт 2,748 тэрбум төгрөг батлуулсан бөгөөд тендер шалгаруулалтын шатанд байна. Гүйцэтгэлийн хувь 0
	4	Сумдад орон сууцны барилгыг ашиглалтад оруулах		Тухайн жилд ашиглалтад орсон орон сууцны тоо		6	4	2021 оны 3 дугаар улирлын байдлаар Сайнцагаан суманд 175 айлын 8 орон сууц, Гурвансайхан суманд 12 айлын 1 орон сууцны барилга тус тус баригдаж байна. Гүйцэтгэлийн хувь 30
Үндсэн чиг үүргийн нэр: 2 Газрын харилцааны бодлого хэрэгжүүлэх								
Зорилт	1	Газрын маргааны асуудал 71 байсныг 2024 онд 36 болгон бууруулна.		Шийдвэрлэлтийн хугацаа		726	394	Сумдын 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд маргаантай байгаа нэгж талбаруудыг эзэмшүүлэхээр тусгуулж маргааныг бууруулна /хугацаа болоогүй/
Арга хэмжээ	1	Өвөлжөө, хаваржааны газрын маргаантай газрыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, шийдвэрлэх		Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өвөлжөө		0	5	Сумдын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд маргаантай өвөлжөө, хаваржааны 14 газрыг тусгасан бөгөөд төлөвлөлтийн дагуу 3 газрыг харьяа сумдын Засаг даргын захирамжаар эзэмшүүлээд байна. 2022 оны сумдын газар зохион байгуулалтын тухайн жилийн

				хаваржааны тоо				төлөвлөгөөнд тусган шийдвэрлэх талаар сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлсэн. Гүйцэтгэлийн хувь 70
	2	Жил бүр аймаг хоорондын хил дамнан олгогдсон өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлүүлэхээр арга хэмжээ авах		Маргааны гаралтын бууралт		0	2	egazar.gov.mn цахим системийн газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн санал авах хэсэгт хил залгаа аймгийн нутагт өвөлжөө, хаваржаа нь орсон иргэдийн газрыг 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар саналыг цахимаар хүргүүлсэн. Гүйцэтгэлийн хувь 70

Үндсэн чиг үүргийн нэр: 1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд нийцсэн, гадаад бодлогын нэгдмэл байдлыг баримтлан аймгийг гадаадад төлөөлөн, гадаад ажил арга хэмжээг оновчтой төлөвлөх, үр дүнтэй зохион байгуулна.

		Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөрөнгө оруулалтын хэмжээг 20 дахин нэмэгдүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилт 2020 онд 70 хувьтай байсныг 2024 онд 95 хувьд хүргэнэ.		Гадаад хамтын ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт		70	80	Гадаад харилцааны 2021 оны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ төлөвлөж ажлын гүйцэтгэлийн явц 70 хувьтай байна. Гүйцэтгэлийн хувь 70
Зорилт	1			Хөрөнгө оруулалтын хэмжээ		500.0	2,000.0	Японы Засгийн газрын санхүүжилттэй “Өвсний Үндэс” хөтөлбөртэй хамтарсан “Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн засварын ажил” төслийн хүрээнд 231,810(652,732,507 сая төгрөг) ам.долларын санхүүжилт хийгдсэн. Дэлхийн зөн Монгол ОУБ-ын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төслөөс шуурганд өртсөн иргэдэд зориулж 10 өрхөд тус бүр 3,700,000 төгрөгний өртөг (нийт 37,000,000 төгрөг) бүхий гэр хандивласан. Мөн төслийн хүрээнд Дэрэн суманд малын тэжээлийн ургамал тариалахад шаардлагатай 51,000,000 төгрөгний үнэ бүхий ургамлын үр, техник төхөөрөмжийг хандивласан. Японы “Хүүхдийг ивээх сан”-гийн “Байгалийн гамшигт өртсөн айл өрх, иргэдэд дэмжлэг

								үзүүлэх” төслийн хүрээнд шороон шуурганд өртсөн иргэдэд өртө 55 гэр, 370 өрхөд эрүүл ахуйн багц, 270 өрхөд бэлэн мөнгөний тусламж нийт 500сая орчим төгрөгний өртөгтэй тусламж үзүүлсэн. Гүйцэтгэлийн хувь 100
Арга хэмжээ	1	Гадаад хамтын ажиллагаатай муж, хот, олон улсын төслийн байгууллагын тоог нэмэгдүүлэх		Нэмэгдүүлсэн улс, орнуудын муж, хотын тоо		3	4	Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яаманд албан бичиг хүргүүлж Орос Улсын муж, хотуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах талаар санал солилцож байна. Гүйцэтгэлийн хувь
				Шинээр нэмэгдсэн олон улсын төслийн байгууллагын тоо		7	9	Аймгийн хэмжээнд нийт гадаадын 11 төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 2021 онд дараах төслүүд шинээр нэмэгдэн хэрэгжиж байна. 1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Японы Засгийн газрын санхүүжилттэй “Өвсний Үндэс” хөтөлбөртэй хамтарсан “Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн засварын ажил” төсөл 2. Дэлхийн зөн Монгол ОУБ-ын “Гамшигт тэсвэртэй орон нутаг” төсөл Японы “Хүүхдийг ивээх сан”-гийн “Байгалийн гамшигт өртсөн айл өрх, иргэдэд дэмжлэг үзүүлэх” төсөл Гүйцэтгэлийн хувь 100
	2	БНХАУ-ын Баяннуур, БНСУ-ын Гуяанг хоттой байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтарсан ажил, арга хэмжээ зохион байгуулах		Тухайн жилд зохион байгуулах арга хэмжээний тоо		0	0	БНХАУ-ын Баяннуур аймагтай хамтын ажиллагааг өргөжүүлэхээр “Найрсаг харилцаа тогтоох тухай хэлэлцээр” байгуулахаар ажиллаж байна. 2021 онд БНСУ-ын Гуяанг хотоос Ногоон Ази Сүлжээ” ОУТББ-аар дамжуулан 19 ажилтныг цалинжуулж усалгаа арчилгаа болон хашаажуулах ажлыг хийж гүйцэтгэн 1 га талбайд төмс, хүнсний ногоо, 6*20 м

								хэмжээтэй 2 ширхэг хүлэмжид огурций, шийгуа, лооль тариалах ажил хийгдэж байна. Гүйцэтгэлийн хувь 100
	3	Төрийн албан хаагчдыг Гадаадад туршлага судлах арга хэмжээнд хамруулах		Тухайн жилд хамрагдсан албан хаагчдын тоо		21	0	10, 11 дүгээр сард ОШУСТ-тэй хамтран Орос хэлний олимпиад зохион байгуулж багш нарыг тэтгэлэгт хамруулахаар төлөвлөж байгаа тул хэрэгжилт гарах хугацаа болоогүй.
Үндсэн чиг үүргийн нэр: 2. Аймгийн хэмжээний нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, сургах, давтан сургах, мэргэшүүлэх, сонгон шалгаруулах, нийгмийн баталгааг хангах, төрийн албаны хууль, ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх								
Зорилт	1	ТАХ-ыг чадавхжуулж орон нутагт дутагдалтай мэргэжлийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлж тогтвортой байдлыг хангана		Тухайн байгууллагад 3-аас дээш жил ажиллаж байгаа ТАХ-ийн дундаж хувь		62	63	ТЗУХ, Сумдын ЗД
				Дутагдалтай мэргэжлийн боловсон хүчний хангалтын хувь		90	91	ТЗУХ, Сумдын ЗД
Арга хэмжээ	1	Аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх		Хэрэгжилтийн хувь		0	30	2021-2025 онд Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлууж ,аймгийн Засаг даргын баталсан 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гүйцэтгэлийн хувь 10
	2	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх		Орон байрны дэмжлэгт хамрагдсан ТАХ-ын эзлэх хувь		9	10	ТЗУХ, Сумдын ЗД
				Төрийн одон медаль болон аймгийн		5	6	Дундговь аймагт олон жил үр бүтээлтэй ажилласан 269 иргэнийг төрийн дээд одон медальд тодорхойлж шагнагдсанаас 80 буюу 29% нь төрийн

				шагналаар шагнагдсан ТАХ-ын эзлэх хувь				албан хаагч, аймгийн шагналаар шагнагдсан нийт 135 иргэний 89 буюу 65% нь төрийн албан хаагч байна. 2021 оны 08 дугаар сарын 30-ны байдлаар аймгийн хэмжээний нийт төрийн албан хаагчийн 5.1 % нь төрийн болон аймгийн шагналаар шагнагдсан байна. Гүйцэтгэлийн хувь 90
				Бусад дэмжлэг тусламж, урамшуулалд хамрагдсан ТАХ- эзлэх хувь		82	83	ТЗУХ, Сумдын ЗД
	3	ТАХ-ыг удирдлагын академи болон гадаад дотоод бусад сургалтанд хамруулах		Гадаад дотоод сургалтанд хамрагдсан ТАХ-дын эзлэх хувь		81	84	ТЗУХ, Сумдын ЗД
	4	ТАХ-ын ёс зүй, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх		ТАХ-ын сахилга хариуцлагын зөрчлийн бууралт		10	9.5	Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэхээр орон нутгийн төсвийн 67 байгууллага “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ээр сургалт болон нөлөөлийн үйл ажиллагааг 67 удаа зохион байгуулж 1317 төрийн албан хаагчийг хамруулсан байна. Ёс зүйн зөрчил гаргасан 16 төрийн албан хаагчид ёс зүйн дүрмийн дугуу хариуцлага тооцон ажилласан. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил 2020 оны мөн үеийнхээс 27% буурсан байна. Гүйцэтгэл хувь 100
Үндсэн чиг үүрэг: 3 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Төрийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох								
Зорилт	1	Ил тод байдлын аймгийн үнэлгээний үзүүлэлтийг 2019 онд 75 хувьтай байгааг 2024 онд 87 хувьд хүргэнэ.		Ил тод байдлын түвшин		75	78	Хугацаа болоогүй

Арга хэмжээ	1	"Цахим төр- Ухаалаг Дундговь" цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх		Хэрэгжилтийн хувь		10	20	Аймгийн Засаг даргын Тамгын газрын интернэт урсалыг 3 дахин нэмэгдүүлж 30 mb болгон 15 сумдын цахим дэд бүтэц интернэтийн хурдыг нэмэгдүүлж, deticait буюу шилэн кабелийн шууд 5 mb урсгалтай болгож, 15 сумдыг интернэтийн бодит хаягтай болгож, сумдын цахим дэд бүтцийг сайжруулсан. Сум байгууллагуудын, цахим хурлын үйл ажиллагааг тогтмолжуулж аймгийн Засаг даргын Тамгын газрын 2 танхимыг цахим хурлын системийн зохион байгуулалтаар тохижуулан 50 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийж, 86 инчийн Ухаалаг дэлгэц, 3х6 мертийн лед дэлгэцийг байршуулан цахим системүүдийн холболтуудыг хийсэн. Сумдын цахим хурлын AVER системийн шинэчлэлтийг хийж 15 сумын цахим сургалт хурлын үйл ажиллагаа тогтмолжуулан аймгийн Засаг даргын шуурхай, Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн онцгой комиссын хурлуудад сумд цахимаар оролцож, мэдээллийн ил тод шуурхай байдлыг ханган ажиллаж 2021 оны эхний 5 сарын байдлаар ЗГХЭГ, УОК, яам, агентлаг болон аймгаас нийт 40 гаруй хурлыг цахимаар зохион байгуулж 15 сумын онцгой комисс, удирдлагууд, төрийн албан хаагчид холбогдох төрийн байгууллагын удирдлага, албан хаагчид цаг алдалгүй оролцсон байна. Гүйцэтгэл хувь 70
	2	Сум, агентлаг, төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдалд хяналт тавих, зөвлөн туслах		Сум, агентлагийн ил тод байдлын үнэлгээний дундаж		75.5	78	ТЗУХ, Сумдын ЗД
	3	Аймаг, сумдын удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга		Уулзалтад хамрагдсан иргэдийн тоо		2000	4000	Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн Бямба гарагт 11.00-16.00 цагт иргэдтэй уулзах уулзалт арга хэмжээг

		хэмжээг сар бүр зохион байгуулах						тогтмол явуулж, 14 удаагийн уулзалтаар 141 иргэдтэй уулзалт зохион байгуулсан. Салбар бүрийн төлөөлөл эмэгтэйчүүд, хүчний байгууллагуудын удирдлагууд нийт 50 гаруй иргэдтэй, 15 сумын Засаг дарга нийт 421 иргэдтэй уулзалт зохион байгуулж ажиллаад байна.
Гүйцэтгэлийн хувь 30								
Ерөнхий чиг үүргийн нэр: 4 Нутаг дэвсгэр, хүн амын аюулгүй байдал								
Үндсэн чиг үүргийн нэр: 1. Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах								
Зорилт	1	Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ.		Хэрэгжилтийн хувь		65	70	Сумдын ЗД Дайчилгааны тухай хууль 18.1.1, 1.2-д заасны дагуу 2021 оны цэргийн тоо бүртгэлийн үеэр сумдын ЗДТГ Батлан хамгаалах багц хууль тогтоомжийг сурталчлан ажилласан. “Улсын дайчилгааны даалгавар”-ын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын даалгаварыг тодотгож сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар нь аймгийн Засаг даргын захирамжид заагдсан хугацаанд Цэргийн штабтай ирж тодотголыг хийж нийлсэн. Гүйцэтгэлийн хувь 70
Арга хэмжээ	1	Цэргийн тоо бүртгэл, цэрэг татлагын үйл ажиллагааг зохион байгуулах		Хяналтын тооны биелэлтийн хувь		90	92	Дундговь аймгийн 2021 оны цэргийн бүртгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 05-26-ны өдрүүдэд зохион байгууллаа. Цар тахалын улмаас цэрэг татлага явагдаагүй. Гүйцэтгэлийн хувь 0
	2	Бүх шатны Засаг дарга, Тамгын газрын дарга, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, орон нутгийн цэрэг, хамгаалалтын нэгжийн цэргийн сургалт зохион байгуулах		Хамрагдалтын хувь		81	82	“COVID-19”-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор Засгийн газрын 2021 оны ... дугаар тогтоолуудаар улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгаж олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарласан тул уг үйл ажиллагаа явагдаагүй.

								9-р сард цахим хэлбэрээр явуулахаар тогтсон.
Хугацаа болоогүй								
Үндсэн чиг үүргийн нэр: 2 . Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах								
Зорилт	1	Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг ханган гамшгаас үүдэлтэй хохирлын хэмжээ 2020 онд 293.9 сая төгрөг байсныг 2024 280.0 сая төгрөг болгон бууруулна.		Гамшгаас үүдэлтэй хохиролын бууралт		293.9	293.5	Гамшигтай тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг ханган сумдын гамшгийн эрсдлийн үнэлгээг сум орон нутгийн хэмжээнд хийж үнэлгээнээс гарсан зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон, гамшгаас хамгаалах албадууд, сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангиудын бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэн, гамшгаас үүдэлтэй хохирлын хэмжээг багасгахаар ажиллаж байна. Гүйцэтгэлийн хувь 30
Арга хэмжээ	1	Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг орон нутгийн нийт хүн амын 30 хувийг хамруулах		Сургалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь		12	15	Гамшгаас хамгаалах мэдлэг ойлголтыг олон нийтэд хүргэх, болзошгүй аюулын үед иргэд өөртөө болон бусдад туслах мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд гамшгаас хамгаалах ангиллын сургалтад 6200 хүн амд буюу орон нутгийн нийт хүн амын 13,1 хувийг хамруулаад байна Гүйцэтгэлийн хувь 30
	2	Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах хүч хэрэгслээр хангах		Хүний нөөцийн нөхөн хангалт		0	50	Хулд суманд Эрэн хайх, аврах бүлэгт ажиллах иргэдийг сонгон шалгаруулж материалыг ОБЕГазарт хүргүүлсэн ахлагчийн сургуульд хамруулсан. Гүйцэтгэлийн хувь 40
				Аврах үйл ажиллагааны дуудлага авснаас хойш аврах үйл ажиллагааг		50	48	Хулд суманд Эрэн хайх, аврах бүлэг байгуулах бэлтгэлийг хангуулан ажиллаж байгаа бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд сум орон нутагтай хамтран байрлах байрыг сонгосон бөгөөд засвар үйлчилгээг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

				бүрэн гүйцэтгэж дууссан дундаж хугацаа				Гүйцэтгэлийн хувь 30
	3	Гамшгийн эрсдэлийг бууруулах “Мазаалай” арга хэмжээг хэрэгжүүлэх		Хэрэгжилтийн хувь		0	30	Хөтөлбөр батлагдаагүй тул хэрэгжих боломжгүй Гүйцэтгэлийн хувь 30
	4	Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, жил бүр 6-аас доошгүй суманд дадлага сургууль үзлэг зохион байгуулах		Дадлага, сургууль зохион байгуулагдсан тоо		6	6	Сумдад зохион байгуулах гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуулийг коронавирус (КОВИД-19)-ын халдварын нөхцөл байдалтай холбогдуулан хойшлуулж 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд бэлтгэл ажлыг хангах чиглэлийг сумдад хүргүүлсэн. Хугацаа болоогүй
Үндсэн чиг үүргийн нэр: 3 Мэргэжлийн хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх								
Зорилт	1	Бага дунд эрсдэлтэй иргэн аж ахуй байгууллагын тоо 2020 онд 2774 байсныг 2024 онд 2994 болгож нэмэгдүүлнэ.		Тухайн жилд бага эрсдэлтэй үнэлэгдсэн ИААНБ-ын тоо		1103	1125	МХГ Эрсдэлийн үнэлгээ, шалгалтын дүнгийн харьцуулалтаар тухайн эрсдэл гардаг. 10 сард эрсдэлийн үнэлгээ хийж нэгдсэн дүн гарна. Хугацаа болоогүй
				Тухайн жилд дунд эрсдэлтэй үнэлэгдсэн ИААНБ-ын тоо		1671	1704	
Арга хэмжээ	1	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг хангуулж албан шаардлагын хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэх		Албан шаардлагын хэрэгжилтийн дундаж хувь		57.6	62	10 сард албан шаардлагын биелэлтэд гүйцэтгэлийн шалгалт хийж биелэлтийг гаргана. Хугацаа болоогүй
	2	Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн ИААНБ-ыг төлөвлөгөөт шалгалтад хамруулах		Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийн тоо		325	344	Коронавирусын халдвараас шалтгаалан уул уурхай болон сумдад хийгдэх шалгалтууд хойшилсон.
	3	ИААНБ-дад салбарын сургалтыг зохион байгуулж		Сургалтад хамрагдсан		440	480	Коронавирусын халдвараас шалтгаалан сургалт хийгдээгүй байна. Гүйцэтгэлийн хувь 0

		мэргэжил арга зүйн удирдлагаар хангах		иргэн, аж ахуй нэгжийн тоо				
	4	Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх.		Тухайн жилд хийх урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоо		28	29	Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалтыг 29 удаа хийсэн Гүйцэтгэлийн хувь 70
Үндсэн чиг үүргийн нэр: 4 Хууль ёс, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах								
Зорилт	1	Гэмт хэргийн гаралт 2019 онд 211 байсныг 2024 онд жил бүр 10-аас доошгүй хувиар бууруулна.		Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо	211	206		Аймгийн хэмжээнд эхний 7 сарын байдлаар 120 гэмт хэрэг бүртгэгдэж гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн үеэс 11 хувиар буурсан. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулах, коронавирус /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 59 мэдэгдлийг аж ахуй нэгж, албан тушаалтанд хүргүүлж 35 албан мэдэгдэлд хариу авч, 15 аж ахуй нэгжийн биелэлтийг газар дээр нь шалгасан. Зохион байгуулсан ажлын үр дүнд аймгийн хэмжээнд хүчиндэх гэмт хэрэг 66.6 хувь, Дээрэм 50 хувь, Хулгайлах гэмт хэрэг 43.7 хувь, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 70.0 хувь, аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг 15.94 хувь тус тус буурсан эерэг үзүүлэлтэй байна. Гүйцэтгэлийн хувь 100
Арга хэмжээ	1	Цагдаагийн газрын хуучин барилгыг засварлаж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, иргэдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх төвийг байгуулж ажиллуулах		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт	9	8		Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг тус оны эхний 7 сарын байдлаар 4 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 1 нэгжээр, зөрчил эхний 07 сарын байдлаар 20 бүртгэгдэж урьд оны мөн үетэй харьцуулахад 4 нэгжээр тус тус өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл өссөнтэй холбогдуулан гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах Түр хамгаалах байртай болох талаар

							Аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт албан бичиг хүргүүлсэн.
							Гүйцэтгэлийн хувь 30
	2	Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах		Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн бууралт	16	13	Улсын хэмжээнд зохион байгуулж буй Ирээдүйгээ хамгаалъя уриатай “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл-2021” нэгдсэн арга хэмжээг 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, аймгийн Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, Цагдаагийн газрын дарга нарын хамтарсан төлөвлөгөөтэй ажиллаж байна. Орон нутгийн зам дагуу аймгийн төвөөс хойш 1 километрт байрлах мэдээллийн самбарт Ирээдүйгээ хамгаалъя уриатай “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2021” арга хэмжээний нөлөөллийн аннос 4х6-ийн хэмжээтэйгээр 4 ширхэгийг байрлуулж аймгаас хойш нутгийн заагт 108 дахь километрт 4х6-ийн хэмжээтэй 2 ширхэг аннос тус тус байршуулан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа. Мөн аймгийн Онцгой байдлын гаднах лед дэлгэцээр зам тээврийн ослоос сэрэмжлүүлсэн, анхааруулсан 21 видео шторк, богино хэмжээний 1 кино, зурагт хуудсыг 2 удаагийн давтамжтай, Аюулаас сэргийлэх FM 107.5-аар 10, facebook хаягт 85 удаагийн мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд тогтмол түгээн сурталчилан ажиллаж байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ноднингийн мөн үеэс 1-ээр буюу 11.1 хувь өссөн үзүүлэлттэй байна
							Гүйцэтгэлийн хувь 70
	3	Албан байгууллага, аж ахуйн нэгжийн санаачлага,			32.7	-	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг

		оролцоотой томоохон гудамж талбай, сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын системийг нэвтрүүлэх		Иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт			хангах зорилгоор 2021 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар Гурвансайхан, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Адаацаг сумдад нэмэлт камержуулалт хийгдэхээр төлөвлөгдөн телехяналтын камеруудын техник эдийн засгийн үндэслэлийг ЦЕГ-ын МШУТ-өөс гаргуулан авч, суурилуулалтын үйл ажиллагаа болон телехяналтын камерын стандарт шаардлага, зөвлөмжийн дагуу тогтмол хяналт тавин ажиллахаар тус сумдын хэсгийн төлөөлөгчдөд хүргүүлсэн. Одоогийн байдлаар Цагаандэлгэр суманд МШУТ-өөс ирүүлсэн техник эдийн засгийн үндэслэлийн дагуу чиглэлийн 4 ширхэг РТЗ 1 ширхэг камерыг суурилуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд иргэдийн өмчийг хулгайлах гэмт хэрэг ноднингийн мөн үетэй харьцуулахад 14 хэргээр буюу 45.1 хувиар буурлаа.
	4	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэдийн сонор сэрэмж, хариуцлагыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах		Мал хулгайлах гэмт хэргийн бууралт	29	28	Гүйцэтгэлийн хувь 70 Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах чиглэлээр аймгийн төвд мал, мах худалдан авдаг 23 иргэн, аж ахуй нэгжийн эрхлэгч нарыг оролцуулан Мал эмнэлгийн газартай хамтран 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээнд хяналт тавих”, мөн сумдын мал эмнэлгийн байцаагч нар болон хэсгийн төлөөлөгч нарт “Мал эмнэлгийн гарал үүсэл, ариун цэврийн гэрчилгээнд хяналт тавихад анхаарах асуудал” зэрэг сэдвүүдээр эрх зүйн сургалтуудыг зохион байгууллаа. Мал бүхий иргэдэд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 100 ширхэг санамж сэрэмжлүүлэг бэлтгэн, малчдад түгээсэн. Түүнчлэн олон нийтийн сүлжээнд

								Дундговь аймгийн алдсан, олдсон малын зарын группыг нээн ажиллуулж, алдсан малын 102 зар, олдсон малын 15 зар мэдээллийг байршуулан ажилласаны үр дүнд тус оны эхний 7 сарын байдлаар мал хулгайлах гэмт хэрэг 9 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй ижил түвшинд байна. Гүйцэтгэлийн хувь 70
Зорилт	2	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж, үйлчилгээг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд хүргэнэ.		Хамрагдсан иргэдийн хувь	10	12		Халдварт цар тахалтай холбогдуулан сумдын “Эрх зүйн хөтөч”-үүдийг чадавхжуулах эрх зүйн албан бус сургалтыг цахим хэлбэрээр аймгийн Шүүх, ШШГГ, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь референт, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч, аймгийн Насан туршийн боловсролын төв зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран 60 эрх зүйн хөтөчүүдэд зохион байгууллаа. Тус онд “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр дээшлүүлэх нь” 3 сарын аяныг зохион байгуулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс нээсэн Эрх зүйн хөтчийн нэгдсэн группт аймаг, сумдын Эрх зүйн хөтөчүүд нэгдэж тус группт тавигдсан хууль, эрх зүйн сурталчилгааны мэдээ, мэдээлэл, 1800-1202 подкастын цуврал дугааруудыг Эрх зүйн хөтөч бүр олон нийтэд сурталчлан таниулж хүргэх ажлыг зохион байгуулав. Мөн Хууль, эрх зүйн хэлтсээс Дундговь “Эрх зүйн хөтөч” группийг нээж Гэр бүл гэж юу вэ, Хүүхдийн тэтгэлэгийн ажиллагаа харандааны адал явдал, Мэдээллийн ил тод байдал, Ахмад настны тухай, Ан амьтны тухай, Байгаль орчны, Эрүүл мэндийн, Хот

							суурин газрыг дахин хөгжүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Хүүхэд хамгаалах тухай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Малын хулгайтай тэмцэх, Ойн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай зэрэг 16 хууль тогтоомжоор бэлтгэсэн шторк зэрэг сурталчилгааг цувралаар иргэд, олон нийтэд хүргэж, нийт 5000 гаруй иргэдэд эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүллээ. Гүйцэтгэлийн хувь 70
Арга хэмжээ	1	Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулах		Зохион байгуулсан сумдын тоо	2	3	Халдварт цар тахалтай холбогдуулан хууль эрх зүйн сургалт, сурталчилгааг сумдад зохион байгуулах боломжгүй байсан тул сумдын Эрх зүйн хөтчүүдийг гудирдлага зохион байгуулалтаар ханган “Иргэн бүрт эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр хүргэх 3 сарын аян”-ыг зохион байгуулан аймаг, сумдын цахим сайт, Д “Эрх зүйн хөтөч” групп, Насан туршийн боловсрол зэрэг цахим сайтуудаар иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэв. Хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад цахим болон өөрсдийн бэлтгэн боловсруулсан гарын авлага, брошур тараах хэлбэрүүдээр зохион байгуулан, эрх зүйн мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааг давхардсан тогоор 319 удаа, 5000 гаруй иргэнд хүргэж, 26637 удаагийн хандалт авсан. Гүйцэтгэлийн хувь 70
	2	Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн		Хууль зүйн туслалцаа хүссэн төлбөрийн чадваргүй иргэдийн СӨГ-	82	86	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь референт, Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нар хамтран иргэдэд хүний эрхийн зөрчлийн талаарх зөвлөгөө, мэдээлэл, хууль зүйн туслалцаа

		туслалцаа, үйлчилгээ үзүүлэх		ын шийдвэрлэлт			үйлчилгээг цахимаар болон биечлэн олгох үйл ажиллагааг хэвшүүлэн ажиллаж байна. Мөн Хуульчийн “Про Боно өдөр-2021”, “Эрх зүйн хөтөчүүдийг чадавхжуулах” арга хэмжээнүүдийг хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, цахим хэлбэрээр иргэд, олон нийтэд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулав. Тус оны 8 сарын байдлаар иргэд, байгууллагаас ХЭҮК-д хандсан санал хүсэлт ирээгүй бөгөөд Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч эрүүгийн 23 хэргийн төлбөрийн чадваргүй 27 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээг үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 234 иргэнд үзүүллээ. Гүйцэтгэлийн хувь 70
Зорилт	3	Төрийн байгууллагуудын Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт 2019 онд 86.9 хувьтай байсныг 2024 онд 93 хувьд хүргэнэ.		Стандарт, журмын хэрэгжилтийн хувь	86,9	87,5	Шинээр батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Монгол Улсын MNS 5140-1:2011 Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандартаар төрийн 22 байгууллагын 261 албан хаагч нарт сургалт зохион байгуулснаар архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт сайжирч байна. Гүйцэтгэлийн хувь 80
Арга хэмжээ	1	Сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдыг мэргэжлийн сургалт, семинарт үе шаттай хамруулж, зөвлөмж, арга зүйгээр хангаж, мэргэшүүлэх.		Холбогдох мэргэжилтэн, албан хаагчдын сургалт, семинарт хамрагдсан хэмжээ	-	60	Архивын мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах сургалтын төвд суралцуулах захиалгыг сум, байгууллагуудаас авч 31 ажилтны захиалгыг Архивын Ерөнхий газарт хүргүүлсэн. Тус газраас анхан болон мэргэшүүлэхийн сургалтыг цахимаар зохион байгуулж, анхан шатны сургалтанд 5, мэргэшүүлэх сургалтанд 13 албан хаагч хамрагдсан. Төрийн архиваас Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоол,

							Зохион байгуулалт, баримт бичгийн стандартаар нийт 22 төрийн байгууллагын 261 төрийн албан хаагчид архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтыг зохион байгуулсан. Архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчлэн батлагдсан эрх зүйн актуудыг сурталчлах, хэрэгжүүлэх хүрээнд “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмыг сурталчлан таниулах” 3 сарын аяныг 2021 оны 02 дугаар сарын 16-наас 05 дугаар сарын 16-ыг хүртэлх хугацаанд сум, байгууллагын хэмжээнд зохион байгууллаа. Гүйцэтгэлийн хувь 100
	2	Архивын баримтын тоо бүртгэлийн мэдээг үнэн зөв гаргаж, Төрийн архивын баримтын 95-аас дээш хувийг цахим хэлбэрт шилжүүлж, ААН, байгууллага, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх.		Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын хэмжээ	90	91	“Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн ажлын хүрээнд 19 хөмрөгийн 342 хадгаламжийн нэгжийн 22429 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, Төрийн архиваас иргэдийн ажилласан жилийн лавлагаа, хуулбар олгох үйлчилгээг тоон гарын үсгээр 10 иргэнд, цаасан болон цахим баримт ашиглан 713 иргэнд төрийн архивын үйлчилгээ үзүүллээ. Гүйцэтгэлийн хувь 70
	3	Сум, байгууллагууд архивтаа зориулалтын нягтруулсан шүүгээ болон орчин үеийн шаардлагад нийцсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлж, архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах,		Тоног төхөөрөмж, техник, хэрэгслийн хангалт	50	70	Төрийн архивт хадгалагдаж байгаа баримт бичиг, хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор 265 хамгаалалтын хайрцаг, цэвэр аюулгүй байдлыг хангах зорилгоор 40м хулдаас авч нийт 1,332,500 төгрөгийг зарцуулж, баримтын хадгалалт хамгаалалтыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Гүйцэтгэлийн хувь 30
Ерөнхий чиг үүргийн нэр: 5 Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлт, төсөв санхүү, статистик							
Үндсэн чиг үүргийн нэр: 1 Төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ							
Зорилт	1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувь		Хэрэгжилтийн дундаж хувь	81.7	82.5	ХШҮДАХ Сум, агентлагийн дарга

		81.7 хувь байсныг 2024 онд 86 хувьд хүргэнэ.						
